
	(ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллеж)	Захирлын 2026 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн ... 11/25 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт
Баталсан: ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал  (Ч.Эрдэнэтуяа)	Баталсан огноо: 2026.02.11	Хуудасны тоо: 5
Баримт бичгийг хариуцагч: Захирлын туслах, архив бичиг хэрэг хариуцсан ажилтан	Танилцах албан тушаалтнууд: Нийт багш, ажилтан	

## “ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ” ЖУРАМ

### Эх хувь

Баримтжуулсан мэдээллийн дугаар:

Хувилбарын дугаар: **V1.2026**

### Түгээлт




Энэ журам нь манай байгууллагын өмч юм. Уг баримт бичгийг бичгээр зөвшөөрөл аваагүй үед бүхэлд нь эсвэл хэсэгчлэн байгууллагаас гадагш түгээхгүй.

Энэ журмын батлагдсан албан ёсны хяналттай хуулбар нь цаасан хэлбэрээр бичиг хэргийн ажилтны баримт бичгийн хавтсанд мөн байгууллагын сервер компьютерт PDF файлаар хадгалагдана. Уг PDF файл зөвшөөрөгдсөн бүх ажилтнууд болон сонирхогч талуудад нээлттэй байна.

Дээр дурдсанаас бусад бүх цаасан болон цахим хуулбарыг зөвхөн лавлагаа болгон ашиглах хяналтгүй хуулбар гэж үзнэ.

### ЗӨВШӨӨРӨЛ

Гарын үсэг нь удирдлагын тогтолцооны энэхүү журмыг хянаж, зөвшөөрснийг гэрчлэх бөгөөд гарын үсэг зурсан талууд энд агуулагдаж буй бүх шаардлагуудыг мэдэж, тэдгээрийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээсэн болохыг харуулна.

	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
Боловсруулсан	ХАБЭА-н мэргэжлийн багш	Баярцэнгэл Сугирзав	2026.02.09	
Хянасан	Захиргаа, аж ахуйн менежер	Шоохүү Оюун-Ухаан	2026.02.11	
Зөвшөөрсөн	ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал	Чимэд Эрдэнэтуяа	2026.02.11	

## НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Журмын өөрчлөлт нь процесс болон бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байгаа эсэхийг хянаж баталгаажуулна. Өөрчлөлтийн агуулга хэсэгт журамд орсон өөрчлөлтийг тэмдэглэнэ.

Өөрчлөлт оруулсан бүлэг	Өөрчлөлтийн товч утга	Хувилбарын дугаар	Сүүлд шинэчлэгдсэн огноо	Боловсруулж, шинэчилсэн албан тушаалтан, овог, нэр	Баталсан албан тушаалтан, овог, нэр

## АГУУЛГА

НЭГ.Үндэслэл.....	1
ХОЁР.Зорилго.....	1
ГУРАВ.Ерөнхий шаардлага.....	1
ДӨРӨВ.Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага.....	2-5
ТАВ.Тоног төхөөрөмжийн бүрдүүлэх материал.....	5
ЗУРГАА.Баримтжуулалт .....	5

## Нэг.Үндэслэл

1.1 Энэхүү журмыг ХЭМАБ-н менежментийн тогтолцооны MNS ISO 45001:2018 олон улсын стандартын 7.1 болон MNS 4930 : 2000 стандартыг үндэслэн боловсруулсан болно.

## Хоёр.Зорилго

2.1 Энэхүү журам нь тоног төхөөрөмжид тавих аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлагыг тогтооно.

## Гурав.Ерөнхий шаардлага

3.1 Тоног төхөөрөмж нь угсрах (зайлшгүй үед задлах), засвар үйлчилгээ хийх, хадгалах, зөөж тээвэрлэх үед аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байна.

3.2 Тоног төхөөрөмж нь түүнийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх үед мөрдөх аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн заавар, дүрэмтэй байна.

3.3 Тоног төхөөрөмж нь ашиглах явцад тогтоосон хэмжээнээс их хорт бодисоор хүрээлэн байгаа орчныг бохирдуулахгүй байвал зохино

3.4 Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа нь дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:

- ажиллах зарчим, зохион байгуулалтын бүдүүвч, аюулгүй эд ангийг зөв сонгосон;
- механикжуулалт, автоматжуулалт, алсын удирдлагын техник хэрэгслийг хэрэглэсэн;
- хаалт, хамгаалах хэрэгслийг хэрэглэсэн;
- тохирох материалыг хэрэглэсэн;
- эргономикийн шаардлагыг хэрэгжүүлсэн;

3.5 Тоног төхөөрөмжийн дагалдах бичиг баримтад ашиглах, зөөж тээвэрлэх, засвар үйлчилгээ хийх болон хадгалах үеийн аюулгүй ажиллагааг хангах шаардлагыг тусгасан байна. Техникийн баримт бичгийн заасан хугацаанд засвар, үйлчилгээ, тохируулгыг байнга хийж байх ба энэ тухай болон төхөөрөмжийн ажиллагаа сул зогсолтын талаар бүртгэл хөтөлж, хяналт тавьж байна.

3.6 Тоног төхөөрөмжийг суурилуулах, их засварын дараа ашиглалтад оруулах үед аюулгүй ажиллагаа хангасан талаар холбогдох байгууллага, албан тушаалтан /хөдөлмөрийн хяналтын байгууллага/-д хянуулж зөвшөөрөл авсан байна.

3.7 Цахилгаан тоног төхөөрөмж нь зураг төслийн дагуу угсрагдсан цахилгааны ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангасан байна.

3.8 Өргөх, тээвэрлэх механизм, даралтат сав, шугам хоолойд зохих журмын дагуу туршилт тохируулга баталгаажуулалт хийсэн байна.



## **Дөрөв.Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага**

4.1 Тоног төхөөрөмжийн бүрэлдэхүүн хэсгүүд (дамжуулах хоолой, цахилгаан дамжуулагч гэх мэт)-г хэвийн ажиллагааны явцад тохиолдлоор бохирдож, эвдэрч аюул, осолд хүргэхгүй байхаар тооцож хийсэн байна

4.2 Хий, уур, даралтат хий шингэний болон өөр төрлийн систем бүхий тоног төхөөрөмжийн хийцэд эдгээр систем тус бүрт мөрдөх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байх бөгөөд технологийн системийн цогцолборт тэдгээрийн ажиллагааны онцлог нөхцлийг тооцсон бөйна

4.3 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюул, ослын эх үүсвэр болж болзошгүй хөдөлгөөнтэй хэсгүүдэд хаалт, хамгаалалтын хэрэгсэл тавьсан байна. Аюул осолд хүргэж болох хөдөлгөөнтэй хэсгүүдийн зориулалт онцлогоос шалтгаалж хаалт, хамгаалалтын хэрэгсэл тавих боломжгүй тохиолдолд тоног төхөөрөмжийг ажиллуулахад анхааруулах дохионы хэрэгсэл болон зогсоох, цахилгаан эрчим хүчний эх үүсвэрээс салгах хэрэгслүүдтэй байвал зохино

4.4 Галын аюулгүй ажиллагааны болон эрүүл ахуйн зохих туршилт хийгээгүй шинэ бодис, материалыг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хийцэд хэрэглэхийг хориглоно

4.5 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хийцийн эд ангиудын аюул, осолд хүргэж болох хурц өнцөг, ирмэг, тэгш бус гадаргуу нь тоног төхөөрөмжийн гүйцэтгэх үүрэгтэй уялдан зайлшгүй байх шаардлагатай бол учирч болох гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгасан байвал зохино

4.6 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хийцийн хэт халуун болон хүйтэн хэсэгт санамсаргүй хүрч ажиллагч осолд орохоос хамгаалсан байвал зохино

4.7 Тоног төхөөрөмжийн ажиллагааны үед үйлдвэрлэлийн байранд гарч байгаа дулаан, чийг, шуугиан, доргион, тоос болон хортой бодисын хэмжээ нь тогтоосон (стандартад заасан зөвшөөрөх) хэмжээнээс хэтэрч үл болно

4.8 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хийцийн бүрэлдэхүүнд орж байгаа ажлын байр, суудал зэрэг нь ажиллахад тохиромжтой, аюулгүй ажиллах нөхцөлийг хангасан байвал зохино. Зайлшгүй тохиолдолд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж гадаад орчны тохиромжгүй нөлөөллөөс ажиллагчдыг хамгаалах бүхээгтэй байна. Бүхээгийн байрлал, хийц нь ажиллагчдын үйл ажиллагааг хүндрүүлэхгүй, аюултай болон хортой нэмэгдэл хүчин зүйлүүдийг үүсгэхгээргүй байна

4.9 Ажиллуулагч нь явж үйлчилгээ хийдэг үйлдвэрийн тоног төхөөрөмж нь үүрэг гүйцэтгэхэд тохиромжтой аюулгүй ажиллагааг хангасан хийц, хэмжээ бүхий тоноггосон хэрэгсэл, байгууламж (ажлын байр, гарц шат, хашлага гэх мэт)-ээр хангагдсан байвал зохино

4.10 Онцгой нөхцөлтэй (нарийн хараа шаардах) ажлын байрны тоног төхөөрөмж нь тухайн нөхцөлд тохирсон зориулалтын хэсэгчилсэн гэрэлтүүлэгтэй байна

4.11 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн удирдлагын систем нь ажил гүйцэтгэх системтэй нэг зэрэг ажиллах үед ямар нэгэн аюул үүсгэхээргүй хийгдсэн байна

4.12 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нь хэвийн ажиллагаа зөрчигдөх үед ажиллах дохиололтой осол гарах, аюулд хүргэж болзошгүй горимоор ажиллах тохиолдолд автоматаар зогсоох, эрчим хүчний эх үүсвэрээс салгах хэрэгсэлтэй байвал зохино

4.13 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн ажил гүйцэтгэх хэсэг, мөн хамах, хавчих, өргөх, зөөх төхөөрөмжүүд нь тэдгээрийг ажиллуулах эрчим хүчний эх үүсвэр (цахилгаан гүйдэл, шингэн, шахагдсан хий гэх мэт) нь тасарснаас үүсэх аюул ослоос урьдчилан хамгаалах эрчим хүчний эх үүсвэрийг дахин залгах үед эдгээр төхөөрөмжүүд өөрөө залгагдахгүй хэрэгслээр тоноглогдсон байвал зохино

4.14 Ажилчдын цахилгаан гүйдэлд нэрвэгдэхээс хамгаалах арга хэмжээг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хийцэд дараах үндсэн шаардлагын дагуу тусгасан байна. Үүнд:

1. үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн гүйдэлтэй хэсгүүд нь найдвартай хөндийрүүлэгдсэн буюу тусгаарлагдсан эсвэл хүн хүрэхээргүй газарт байрласан байх;
2. үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн металл хэсгүүдийг газардуулгатай холбосон байх;
3. үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн цахилгааны бүдүүвчид бүх цахилгаан хэлхээг тэжээлийн сүлжээнээс салгах төвлөрсөн төхөөрөмж тавьсан байна. Цахилгаан эрчим хүчний тусгай эх үүсвэрээс үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг тэжээж байгаа тохиолдолд цахилгаан хэлхээг таслахгүйгээр тэжээлийн эх үүсвэрийг салгах замаар хүчдэлийг арилгах боломжтой байх;

4.15 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нь цахилгаан статик цэнэгийг аюултай хэмжээгээр хуримтлуулахгүй байх ёстой

4.16 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нь ажлын явцад үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалж ялгарах хортой, тэсрэх болон галын аюултай бодис үүсч, хуралдаж байгаа бол орчноос нь зайлуулах тусгай төхөөрөмжтэй байна

4.17 4.15 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нь зайлшгүй тохиолдолд хорт бодисыг тусгай хураагуурт зайлуулах, эсвэл дахин ашиглах болон хоргүй болгох төхөөрөмжтэй байвал зохино



4.18 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нь хэт өндөр, хэт богино давтамжтай дуу шуугиан, доргилтгүй байх, эсвэл тэдгээрийн төвшинг тогтоосон хэмжээнд хүртэл бууруулах боломжтойгоор хийгдсэн байвал зохино

4.19 Ажлын явцад хорт цацраг үүсдэг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг эдгээр нь цацрагаас хамгаалах болон түүнд хяналт тавих багаж хэрэгслээр тоноглогсон байвал зохино

4.20 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг удирдах байгууламж нь үйлдлийг зөв дарааллаар гүйцэтгэх тодорхой заавар, бүдүүвчтэй байна

4.21 Агаарын салгуурын удирдах байгууламж нь улаан өнгөтэй, удирдлагын бусад эд ангиас хэлбэрээрээ өөр, түүний байрлалын заасан тэмдэгтэй, ажиллуулах заавартай, ашиглахад хялбар, ослын байдал арилгаагүй нөхцөлд тоног төхөөрөмж ажиллахгүй байхаар хийгдсэн байна

4.22 Хэд хэдэн хүн зэрэг үйлчлүүлж ажиллуулдаг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн удирдах байгууламж нь үйлдлийн зохих дарааллыг хангаж чадах автомат хэрэгсэлтэй байвал зохино. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн харагдахааргүй далд байрласан аюултай хэсэг нь аюул ослоос урьдчилан сэргийлэх нэмэлт салгууртай байвал зохино

4.23 Аюултай байдлыг анхааруулсан дохиоллын хэрэгсэлд дуут гэрлэн болон өнгөт дохиог хэрэглэж болно

4.24 Дохиоллын төхөөрөмж, хэрэгслийг ажилчдад сонсогдож, харагдах бүсэнд байрлуулсан байна

4.25 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюултай хэсгүүд нь дохионы өнгөөр будагдсан эсвэл тэдгээр дээр аюулгүй ажиллагааны тэмдгүүдийг тавьсан байна

4.26 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хийцэд хамаарах хамгаалах хэрэгсэл нь дараах шаардлагыг нь хангасан байна. Хамгаалах хэрэгсэл нь тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангах бүрэн найдвартай байх. Хэрэв хамгаалах хэрэгсэл нь гэмтэлтэй буюу салгагдсан тохиолдолд уг тоног төхөөрөмжийг ажиллуулж болохооргүй хийгдсэн байх

4.27 Аюул осолтой бүсэнд хүн ойртоход болон аюул осол үүсэх үед хамгаалах хэрэгсэл нь найдвартай ажилладаг байх

1. Үйлдвэрлэлийн аюултай болон хортой хүчин зүйлүүд арилах хүртэл хамгаалах хэрэгсэл ажиллаж байх
2. Нэг хамгаалах хэрэгсэл ажиллагаагүй болсон нь бусад хэрэгслийн хамгаалах үйл ажиллагаанд нөлөөлөхгүй байхаас гадна өөр төрлийн аюултай байдал бий болгохгүй байх
3. Үйлчилгээ хийж хяналт тавихад тохиромжтой байх



4.28 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж ажиллаж байгаа үед үүсэх аюул, ослоос хамгаалах зорилгоор хийгдсэн нээгдэж, сөхөгдөх, авагдах хаалтыг нээх үед уг тоног төхөөрөмжийн ажиллагааг зогсоох автомат хэрэгсэл тавигдсан байна.

4.29 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг ажиллаж байх үед нь үзлэг, засвар, үйлчилгээ хийхийг хориглоно.

4.30 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүнийг бүрдүүлэх хэсгүүд нь оосорлоход тохиромжгүй хийцтэй бол өргөх зөөвөрлөхөд тусгай хэрэгслээр хангагдсан байна.

### **Тав.Тоног төхөөрөмжийн бүрдүүлэх материал**

5.1 Машин механик, тоног төхөөрөмжийн техникийн паспорт, баримт бичиг, угсарч суурилуулсан ажлын акт, зураг, схем

5.2 Ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны заавар (Монгол хэл дээр)

5.3 Машин механизм, тоног төхөөрөмжид туршилт тохируулга хийсэн, ажиллуулж шалгасан, хүлээн авсан акт

5.4 Машин механизм, тоног төхөөрөмж нь үйлдвэрлэлийн явцад байгаль орчинд нөлөөлөх, хүний амь нас, эрүүл мэндэд аюулгүй болохыг тогтоосон холбогдох мэргэжлийн байгууллагын экспертийн магадалгаа, экспортлогч талын албан ёсны дүгнэлт

### **Зургаа.Баримтжуулалт**

6.1 Техник ашиглалтын паспорт

### **Долоо.Холбогдох баримт бичгүүд**

Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл олгох бүртгэл

Тээврийн хэрэгсэлийн үзлэгийн хуудас

Зүү ашиглах бүртгэл